



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/86

Улаанбаатар хот


Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.8.2, 4.12.14, 9.2 заалт, Ректорын зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг хавсралтаар баталж, 2016/17 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Сургалт эрхэлсэн проректор /Х.Энхжаргал/, Оюутны хөгжил, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор /П.Жаргалтуяа/, бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ректорын 2004 оны 262 тоот тушаалаар батлагдсан “Ректорын нэрэмжит тэтгэлэлт хамруулах журам”, 2009 оны 253 тоот тушаалаар батлагдсан “Шилдэг оюутан шалгаруулах журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР

Б.ОЧИРБАТ



РЕКТОРЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

ШУТИС-ийн Ректорын санаачилгаар оюутнуудын сурч боловсрох идэвхийг дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудыг урамшуулах, амьдралын боломж муутай оюутнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор амжилттай суралцаж байгаа бакалавр, магистр, доктор оюутнуудыг урамшуулахад энэхүү тэтгэлгийн зорилго оршино.

1.1 Дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан суралцагчид Ректорын нэрэмжит тэтгэлгийг олгоно. Үүнд:

1.2 Шилдэг суралцагч оюутан

- 1.2.1 3,6 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй 2 улирал дараалан суралцсан байх;
- 1.2.2 Олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцож шалгарсан байх;
- 1.2.3 Оюутны эрдэм шинжилгээний ажил, олимпиадад амжилттай оролцож шалгарсан байх;
- 1.2.4 Сайн дурын үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцсон байх;
- 1.2.5 Оюутны бусад тэтгэлэгт хамрагдаагүй байх;

1.3 Шилдэг элсэгч оюутан

- 1.3.1 Амьжирааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой өрхийн суралцагч байх;
- 1.3.2 Монгол улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр элссэн суралцагч байх;
- 1.3.3 Бүрэлдэхүүн сургуульд өндөр оноогоор элсэн орсон суралцагч байх;

1.4 Шилдэг төгсөгч оюутан

- 1.4.1 Үнэлгээний голч дүн 3,20 ба түүнээс дээш байх;
- 1.4.2 Эрдэм шинжилгээ, сурлага, урлаг, спортоор шилдэг төгсөгч байх;
- 1.4.3 Шинэ санаа, үр дүнг хэвлэн нийтлүүлсэн техник технологийн ололт амжилтыг хэрэглээнд нэвтрүүлсэн байх;
- 1.4.4 Сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцож, зохион байгуулсан байх;

1.5 Коосэн загварын Технологийн дээд сургуулийн суралцагч

- 1.5.1 Олон улс болон улсын чанартай олимпиадын гурав, дөрвийн даваанд амжилттай оролцож шагналт байранд орсон байх;

ШУТИС-ийн Ректорын 2016 оны
06 дугаар сарын 10-ны өдрийн
4/86 тоот тушаалын хавсралт

- 1.5.2 Улсын чанартай олимпиадын хоёрын даваанд амжилттай оролцож шагналт байранд орсон байх;
- 1.5.3 3,20 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй 2 улирал дараалан суралцсан, санхүүгийн хувьд дэмжлэг авах шаардлагатай суралцагч байх;

Хоёр. Материал хүлээн авах, шалгаруулах

- 2.1 Энэхүү журмын болзол хангасан суралцагчийг бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, оюутны зөвлөлтэй хамтарсан хурлаар хэлэлцэж хурлын протоколын хамт тэтгэлгийн комисст ирүүлнэ.
- 2.2 Ректорын тушаалаар батлагдсан тэтгэлгийн комисс шилдэг суралцагчийг шалгаруулан Ректорын нэрэмжит тэтгэлгийг олгох тухай Ректорын тушаал гаргана.
- 2.3 Тэтгэлэгийн болзол хангасан элсэгч, суралцагч, төгсөгчийн холбогдох материалыг жил бүр 2 удаа комисст ирүүлнэ.
- 2.4 Тэтгэлэгт шалгарсан суралцагчид өргөмжлөл, тэтгэлгийг Хичээлийн жилийн нээлт, төгсөлтийн ёсполын ажиллагаан дээр гардуулна.
- 2.5 1.4-т заалтын болзол хангасан төгсөгч оюутанд Ректорын гарын үсэг бүхий өргөмжлөл, мөнгөн шагналыг Төгсөлтийн ёсполын ажиллагаан дээр гардуулна.

Гурав. Ректорын нэрэмжит тэтгэлгийн хэмжээ

- 3.1 Ректорын нэрэмжит тэтгэлэгт жил бүр 50 хүртэл оюутныг шалгаруулж, тус бүр 30 хүртэл кредитийн тэтгэлэг олгоно.
- 3.2 Тэтгэлэгт бүрэлдэхүүн сургууль бүрээс жилд 5 хүртэл оюутныг тодорхойлно.
- 3.3 1.5.1 дэх заалтын хангасан суралцагчид сургалтын төлбөрийн 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.
- 3.4 1.5.2, 1.5.3 дахь заалтыг хангасан суралцагчид сургалтын төлбөрийн 50 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.

Дөрөв. Тэтгэлэгт хамрагдах оюутны бүрдүүлэх материал

1. Сургуулийн тодорхойлолт (дэлгэрэнгүй)
2. Суралцагчийн дүнгийн жагсаалтыг улирлаар хэвлэж Сургалтын алба баталгаажуулсан байх;
3. Онлайнаар бөглөсөн оюутны анкет;
4. Хурлын протокол;
5. Амжилт гаргасныг нотлох бичиг баримтын хуулбар